



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Булган аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газрын
2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БУА-2020/137/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Булган аймаг

2020 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр

Утас: 90900910 Цахим хаяг:

Аудитын менежер: Ж.Энхцоодол

Утас: 99057478 Цахим хаяг:

Аудитор: Г.Намчинсүрэн

Утас: 91995689 Цахим хаяг: Namchinsuren999@gmail.com

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|-------------------------------------------------------------|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

Агуулга

| | | |
|-------|--------------------------------------------------------------------------------------------------------------|-------------------------------------|
| 1 | Аудитын гэрчилгээ | 3 |
| 2 | Аудитын тайлан | 6 |
| 2.1 | Оршил | 6 |
| 2.2 | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 6 |
| 2.3 | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт..... | 7 |
| 2.4 | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 7 |
| 2.5 | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ..... | 8 |
| 2.6 | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 9 |
| 2.7 | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 9 |
| 2.8 | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 12 |
| 2.8.1 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал..... | 13 |
| 2.9 | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 13 |
| 2.10 | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга..... | Error! Bookmark not defined. |
| 2.11 | Шилэн дансны мэдээлэл..... | 13 |
| 2.12 | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 13 |
| 2.13 | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 14 |
| 3 | Менежментийн захидал | 15 |
| 4 | Аудит хийсэн санхүүгийн тайлан | 18 |

1 Аудитын гэрчилгээ

| | | |
|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|--|--------------------------------------------------------------------------------|
|  БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР | | ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗРЫН ДАРГА Н.БАТЖАРГАЛ ТАНАА |
| 63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг, Утас: 7034-2580, Факс: 7034-2580 | | |
| 2020.02.03 № 20 | | |
| танай _____-ны № _____ т | | |
| Аудитын гэрчилгээ | | |
| <p>Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.</p> | | |
| Зөрчилгүй санал дүгнэлт | | |
| <p>Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.</p> | | |
| Санал дүгнэлтийн үндэслэл | | |
| <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.</p> | | |
| <p>Аудитаар Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.</p> | | |
| <p>Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.</p> | | |
| | | 006020039 |

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

ДАНХБАЯР



Аудитын тайлан

2.1. Оршил

Хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг ХХҮГ-ын дарга Батжаргал-д танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 02 дугаар сарын 03-ны өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 02 дугаар сарын 05-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Булган аймгийн аудитын газрын Г.Намчинсүрэн хариуцаж хэрэгжүүлэв.

Булган аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн аудитын газарт 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01/39 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго: Төрийн хууль, ёс зүйн хэм хэмжээг чанд сахиж, ил тод нээлттэй, шударга байх зарчмыг баримталж, иргэдэд үзүүлэх нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээг чанартай, үр дүнтэй, шуурхай хүргэнэ гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газар нь үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх, ажлын байр бий болгох, энэ чиглэлээр салбар хоорондын зохицуулалт хийх;
- Цалин хөлс, хөдөлмөрийн харилцааны оновчтой тогтолцоо, хөдөлмөрлөх таатай орчныг бүрдүүлэх;
- Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тулгуурласан мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог хөгжүүлэх, мэргэжилтэй ажилтан бэлтгэх, ажиллах хүчний зохистой нөөцийг бий болгох, ажиллах хүчний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;
- Хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, ажилгүйдэл, ядуурлыг бууруулах, иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх;

- Монгол хүний амьдралын чанарыг дээшлүүлж, хүн амын хөгжлийг хангах нийгмийн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн нийгмийн цогц бодлого боловсруулж хэрэгжүүлэх;
- Нийгэм, эдийн засгийн өөрчлөлт, хүн амын насны бүтцийн хэтийн төлөвийг харгалзан хүн амын бүлгүүдийн хэрэгцээнд нийцсэн нийгмийн даатгал, нийгмийн халамжийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх замаар хүн амын нийгмийн хамгааллыг сайжруулах;
- Салбарын хүний нөөц, удирдлагын чадавх, зохион байгуулалтыг сайжруулах замаар үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг тасралтгүй дээшлүүлэх.

Тухайн байгууллагын удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2019 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд Шаардлагагүй буюу мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Булган аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACLOUSE” программ хангамж ашигладаг байна.

Тус байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 30 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 5 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 459272.1 мянган төгрөгөөс тооцон 9185.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг нийт зардлын 16107.3 мянган төгрөгөөр тооцсон нь Байгууллагын нийт болон цэвэр хөрөнгөөс материаллаг түвшинг тогтооход материаллаг байдлын түвшин хэт өндөр гарч байгаа, нийт орлогын хувьд дээшээ шууд төвлөрүүлдэг тул нийт зардлын 2 хувиар материаллаг байдлын түвшинг тогтоох нь зүйтэй гэж үзлээ.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хөдөлмөр халамж үйлчилгээний 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 106244216.52 мянган төгрөгөөр буюу 7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---------------------------------------------------|----------------------|----------------------|----------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | 639995.0 | 639995.0 |
| Авлага | 5382197.58 | 5249701.0 | -132496.58 |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 67647949.94 | 57228385.26 | -10419564.68 |
| Үндсэн хөрөнгө | 1372239826.44 | 1275907676.18 | -96332150.26 |
| Нийт хөрөнгө | 1445269973.96 | 1339025757.44 | -106244216.52 |
| Өр төлбөр | 789907.0 | -789907.0 | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1444480066.96 | 1339025757.44 | -105454309.52 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1445269973.96 | 1339025757.44 | -106244216.52 |

Авлага дансны үлдэгдэл 132.5 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны авлагаас 2.4 хувь барагдсантай холбоотой байна. Авлага дансны үлдэгдэлд 2009-2012 онд үүссэн, он удаан жил болсон 3249.7 мянган төгрөгийн байгууллагаас, 2000.0 мянган төгрөгийн хувь хүнээс авах авлага байна. Үүнээс эзэн холбогдогч нь тодорхойгүй шалтгааны улмаас барагдах боломжгүй, эрсдэлтэй 3249.7 мянган төгрөгийн авлага байна. Энэ нь 2009 онд үүссэн 2164.7 төгрөгийн авлага нь тухай эзэн холбогдогч нь тодорхойгүй ажиллагсадтай холбоотой авлага гэсэн дансанд бүртгэлтэй байдагтай холбоотой бөгөөд цаашид тухайн байгууллагын санхүүгийн дүгнэлтэд материаллаг хэмжээгээр нөлөөлөх эрсдэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл буурсан нь 27320.3 мянган төгрөгийн бараа материал акталсантай холбоотой байна. Бараа материал дансны үлдэгдэлд 2012-2019 онуудад худалдан авсан ашиглаж байгаа 5722.4 мянган төгрөгийн бараа материал байна.

Оны эцэст түлш шатахууны зардал 1680.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь нэмэлт санхүүжилтийн данс дахь 2020 оны 1-3 сарын өрхийн судалгааны тээвэр шатахууны зардалд зарцуулагдахаар тооцогдон нөөцөлсөн, хүнсний материалын зардал 6288.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь дараа оны хэрэгцээнд хэрэглэхээр нөөцөлсөн нь хавар болохоор махны үнэ өсөж, чанар сайтай мах олддоггүй өндөр үнэтэй байдгаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь хэдийгээр Швейцарын хөгжлийн агентлагаас хөрөнгө оруулалт хийж Залуучуудын хөгжлийн төв байгуулсантай холбоотой үндсэн хөрөнгө нэмэгдсэн ч тайлант онд 22279.2 мянган төгрөгийн хөрөнгө акталсан мөн тухайн оны элэгдлийн зардал тооцогдсонтой холбоотой байна.

Хөрөнгө оруулалтаар 8787.8 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан мянган 28030.6 мянган төгрөгийн хөрөнгөөр үндсэн хөрөнгө нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгө акталсан 22279.2 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Биет бус хөрөнгө нь тайлант онд 1000.0 мянган төгрөгөөр буурсан нь 1000.0 төгрөгийн дүнтэй хөрөнгө акталсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл буурсан нь эзэн холбогдогч нь тодорхойгүй 789.9 мянган төгрөгийг өмнөх үеийн үр дүнд бичилт хийж бууруулсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1339025.7 мянган төгрөг болж 105454.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүнгээс шалтгаалжээ.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга хийгдээгүй болно.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хуульд зааснаар Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар нь тайлант онд 96638.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсанаас гүйцэтгэлээр 102170.8 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 105.7 хувиар биелүүлсэн байна.

Хүснэгт 2. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|------------------------|------------|-----------|--------|-------|
| Үйл ажиллагааны орлого | 966380.0 | 102170.8 | 5532.8 | 105.7 |
| | | | | |
| | | | | |
| Нийт дүн | 966380.0 | 102170.8 | 5532.8 | 105.7 |

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн урсгал зардалд 627182.0 мянган төгрөгийг зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 530880.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 96638.0 мянган төгрөгийг үндсэн болох туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нийт урсгал зардлын 96638.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр туслах үйл ажиллагааны орлогыг 5532.8 мянган төгрөгөөр давуулан биелүүлж улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Урсгал зардлыг 627182.0 мянган төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 627413.9 мянган төгрөгийг зарцуулж төсвийн гүйцэтгэл 100 хувьтай байгаа нь төсвийг оновчтой төлөвлөж, зарцуулсантай холбоотой байна.

Нэмэлт төсөв: Гадаад төсөл хөтөлбөрөөс 476.0, Засгийн газрын нөөц хөрөнгөөс 800.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 23795.1 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 11715.2 мянга, нийт 36786.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бараа, үйлчилгээний зардалд 8695.0, норматив зардалд 267.0, эд хогшил худалдан авах зардалд 2699.9, томилолтын зардалд 2660.9, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 5000.0, бараа үйлчилгээний бусад зардалд 8123.1, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардалд 9014.9 нийт 36786.3 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 325.328 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын 25 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 7 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 18 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэнээс гадна 0 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй

асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|-------------------------------------------------|-----|----------|---------|
| 1 | Зөвлөмж өгсөн | 4 | 3,169.20 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 2 | 421.10 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 1 | 5,249.70 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0.00 | |
| | Дүн | 7 | 8,840.00 | |

2.10.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

1. Өмнөх санхүүгийн аудитаар илэрсэн зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй тайланд онд авлагын үлдэгдэл 5249.7 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх” гэсэн заалттай, санхүүгийн тайлангийн аудитын үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлсэн.

2. Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг, хөнгөлөлт олгох журмыг зөрчин 1 ахмад настанд ахмадын зориулалттай амралтад жилд 2 удаа хөнгөлөлт үзүүлэн 117.0 төгрөгийг зарцуулсан нь Ахмад настанд үйлчилгээ үзүүлэх, дэмжлэг, хөнгөлөлт олгох журамтай нийцэхгүй, иж бүрэн байх, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосныг аудитын явцад барагдуулсан.

3. Шатахууны зардлыг тооцон олгохдоо холбогдох автомашины зарцуулах шатахууны норм нормативыг баримтлаагүй нийт 304.1 мянган төгрөгийг олгож Дэд бүтцийн сайдын 2004 оны 109 дүгээр тушаалыг хэрэгжүүлж ажиллаагүй, үнэн зөв байдал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосныг аудитын явцад барагдуулсан.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Байхгүй

2.12. Шилэн дансны мэдээлэл

Булган аймгийн Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

2.13. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2019 оны жилийн эцсийн байдлаар Өмнөх тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг 100 биелүүлэн ажилласан байсан.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.14. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Нийгмийн халамж, үйлчилгээний хэлтсийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Нийгмийн халамж, үйлчилгээний газрын 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

2 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Орлого данстай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагааны бэлэн мөнгөний орлогын баримт дээр тухай бүр хураан авсан он сар өдрийг бичихгүй байгаа нь Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 276 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.12, 8.1-д заасан заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.2. Эрсдэл:

Холбогдох дүрэм журам зөрчигдөх, ашиг сонирхлын зөрчил үүсэх.

1.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 276 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3.12, 8.1-д заасан заалтыг хэрэгжүүлж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

2. Зардал данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас бичиг хэргийн зардал 18.0, урсгал засварын зардал 609.7, бичиг хэргийн зардал 43.0, мэдээлэл технологийн зардлаас бичиг хэргийн зардалд 654.3, бага үнэтэй түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардлаас 583.0 мянган төгрөгийг бичиг хэргийн зардалд

нийт 1908.0 мянган төгрөгийг бүлэг хооронд шилжүүлэх зарцуулсан нь Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.5 дахь заалт, сангийн сайдын 2015 оны 01 дүгээр 20-ны өдрийн 7-р тушаалыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.

2.2. Эрсдэл:

Холбогдох дүрэм журам зөрчигдөх, батлагдсан төсөв хүрэлцэхгүй байх.

2.3. Өгсөн зөвлөмж:

Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 5.5 дахь заалт, сангийн сайдын 2015 оны 01 дүгээр 20-ны өдрийн 7-р тушаалыг бүрэн хэрэгжүүлж ажиллах.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

3. Зардал данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Бичиг хэргийн зардалд хамааралгүй 120.0 мянган төгрөгийн ном, 474.2 мянган төгрөгийн хард дискийг тус тус бүртгэсэн нь Сангийн сайдын 2014 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 55 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

3.2. Эрсдэл:

Холбогдох дүрэм журам зөрчигдөх

3.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСННБОУС-ын холбогдох заалтыг хэрэгжүүлэн ажиллах

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн.

4. Зардал данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

